



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2020. 11. 27 № 28

Асуулт тавих тухай

Дэлхий дахинд хурдацтай тархаж байгаа Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал манай улсад тархаад нөхцөл байдал хүнд байна. Цар тахлын улмаас эдийн засаг хүнд хэцүү байгаа хэдий ч дэлхийн улс орнууд Монгол Улсад тусламжийн гараа сунган хандив өгсөөр байгаа билээ.

Монгол Улсын Их Хурлын түр хорооны 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг хэлэлцэх, хяналт тавих, санал, дүгнэлт гаргах талаарх асуудлыг хэлэлцсэн. Тус түр хорооны хуралдаанаар “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын зарим гишүүдээс “халдвар авсан нэг өвчтөнг эдгээхэд зориулан зарцуулж буй мөнгөн дүнгийн талаар” асуусан асуултад Эрүүл мэндийн сайд Та нэг өвчтөнд найм орчим сая төгрөг зарцуулж байгаа тухай чуулганы танхимд мэдээлсэн.

Улсын төсөв, эдийн засаг хүнд байгаа энэ цаг үед, түүнчлэн хандивлагч орнуудын илгээж буй хандив, тусламж хэрхэн үр ашигтай зарцуулагдаж байгаатай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т тус тус заасныг үндэслэн Эрүүл мэндийн сайд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсад Коронавируст халдвар /КОВИД-19/ авсан нэг өвчтөнд зарцуулж байгаа найман сая төгрөгийн задаргааг дэлгэрэнгүй байдлаар ирүүлэх;
2. Өвчтөнд зарцуулж байгаа найман сая төгрөг нь тухайн өвчтөний хүнд, хөнгөн өвдсөн эсэхээс хамааралтай байгаа эсэх;
3. Халдвар авсан өвчтөний ойрын хавьтал болон тусгаарлагдаж байгаа иргэдийг эмчлүүлэгсдийн тоонд хамруулж байгаа эсэх талаарх мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар бэлтгэн ирүүлнэ үү.

Асуултын заалт тус бүрээр хариу тайлбарыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8-д заасан хугацаанд бэлтгэн ирүүлж, улмаар холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ц.ТУВААН

2020000051